

ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өмнөговь Гурван сайхан орон сууцны корпораци ХХК-ын 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ӨМА-2023/17/НА-СТА-ОНА

Цахим хуудас:
www.audit.mn
Даланзадгад хот
2023 он

Тэргүүлэх аудитор: Ц.Өсөхбаяр
Утас: 70533539 Цахим хаяг: usukhbayarts@audit.gov.mn
Аудитын менежер: Т.Хонгорзул
Утас:99014247 Цахим хаяг: khongorzult@audit.gov.mn
Ахлах аудитор: Ж.Болормаа
Утас:80077408 Цахим хаяг: bolormaaja@audit.gov.mn
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн:
Гэрэлт хөхийн тэнцвэр аудит ХХК
Утас:99099119 Цахим хаяг:gerelthuhaudit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

2023.08.15 № 248

танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Өмнөговь Гурван сайхан орон сууцны корпораци ХХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Гурван сайхан орон сууцны корпораци ХХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлангийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовн ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Тайлант хугацаанд байгууллагын дансаар урьдчилгаа авч буцаан суутгаагүй, хууль, журам зөрчин урамшуулал олгосон, анхан шатны иж бүрдэл дутуу баримтаар гүйлгээ хийсэн, хувийн харилцах дансаар мөнгө хүлээн авсан, дэд захирал томилж ажиллуулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7, 18 дугаар зүйлийн 18.1, 20 дугаар зүйлийн 20.2.3, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 5.4 дахь заалттай тус тус нийцээгүй, "Тохиолдсон байх", "Иж бүрэн байх", "Нийцсэн бөгөөд зохистой байх", "Үнэлгээ ба хуваарилалт" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Гурван сайхан орон сууцны корпораци ХХК нь аймгийн төв болон сумдад нийт 179 орон сууцыг хариуцан бага орлоготой айл өрхийг хямд үнэтэй түрээсийн орон сууцаар хангах зорилготой ажилладаг байна.

Аудитын гол асуудал

Тус байгууллагын техник эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд 21 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

016020350

Бусад асуудлын хэсэг

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ӨСӨХБАЯР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

(сая төгрөгөөр)		
Үзүүлэлт	2021.12.31	2022.12.31
Санхүүгийн байдлын тайлан		
Эргэлтийн хөрөнгийн дүн	321.7	484.7
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	11,079.2	14,072.2
Нийт хөрөнгийн дүн	11,400.9	14,556.8
Нийт өр төлбөрийн дүн	11,305.9	14,264.7
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	95.0	292.1
Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	11,400.9	14,556.8
Орлогын дэлгэрэнгүй тайлан		
Борлуулалтын орлогын дүн	366.7	626.2
Үйл ажиллагааны зардал болон ББӨ-н дүн	256.3	407.2
Татварын өмнөх ашиг	109.3	219.0
Татварын дүн	10.9	21.9
Татварын дараах ашиг	98.4	197.1
Олз/ гарз	-	
Цэвэр ашиг	98.4	197.1
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан		
Өмч	0.008	0.008
Дахин үнэлгээний нэмэгдэл		
Хуримтлагдсан ашиг	67.2	292.1
Эцсийн үлдэгдэл	67.2	292.1
Мөнгөн гүйлгээний тайлан		
Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	324.3	748.5
Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	280.6	548.3
Үйл ажиллагааны ЦМГ	63.5	216.8
Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	43.7	200.2
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	171.1	214.8
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	214.8	414.9
Зорилтот түвшин	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
Нийт борлуулалтын орлого	627.6	626.2
Үйл ажиллагааны зардал	410.2	407.2
Үйл ажиллагааны бус зардал	-	-
Нийт зардал	410.2	407.2
Татвар төлөхийн өмнөх ашиг	198.9	219.0
Татвар	19.9	21.9
Татварын дараах ашиг	179.0	197.1
Олз/ гарз		
Цэвэр ашиг	179.0	197.1

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1.0 сая төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 1.0 сая төгрөгийн 1 алдааг залрууллаа.

Үүнд: Байгууллагаас төлсөн төлбөрийн актыг авлагаар бүртгээгүй байгааг залруулж хувь хүнээс авах авлагаар бүртгэлээ.

Аудитаар нийт 27.1 сая төгрөгийн зөрчил² илэрснээс, 2.3 сая төгрөгийн 2 төлбөрийн акт, 14.4 сая төгрөгийн 3 албан шаардлага, 10.4 сая төгрөгийн 1 заалт бүхий зөвлөмж өгөгдлөө.

5.1 Төлбөрийн акт

5.1.1 Цалингийн бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Байгууллагын дарга 2022 оны 12 сард өөртөө тушаал гарган 0.9 сая төгрөгийн урамшуулал авсан байна.

Энэ нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д “Албан тушаалтан өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхолд нийцүүлэн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, мөн эдгээрт бэлтгэхэд өөрийн албан тушаалын байдлаа ашиглан аливаа хэлбэрээр хөндлөнгөөс нөлөөлөхийг хориглоно” гэсэн заалттай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Өөртөө тушаал гарган авсан захирлын урамшууллыг төсвийн орлого болгох төлбөрийн акт тогтоов.

5.1.2 Төрийн хэмнэлтийн тухай хуультай холбоотой асуудал

Илрүүлэлт: Тус байгууллагын гүйцэтгэх захирлын 2022 оны 11 сарын 10-ны өдрийн Б/16 дугаар тушаалаар дэд захирлын орон тоонд хүн 11, 12 саруудад нийт 1.4 сая төгрөгийн цалин олгожээ.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4-д “Энэ хуульд заасныг зөрчиж тэргүүн дэд, дэд, орлогч дарга, зөвлөхийн чиг үүрэгтэй ижил эрх, үүрэг бүхий өөр нэршилтэй албан тушаалын орон тоо бий болгох, түүнд аливаа албан тушаалтныг томилох, орон тоог хэвээр хадгалахыг хориглох” гэсэн заалттай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллаж дэд захирлыг орон тоонд томилогдсон хүнийг албан тушаалаас нь чөлөөлж албан тушаалд ажиллах хугацаанд нь олгосон 1.4 сая төгрөгийг төсвийн орлого болгох төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

5.2.1 Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант хугацаанд Шилэн дансны тухай хуульд заасан нийт 166 мэдээлэл мэдээлэхээс 127 мэдээллийг хуулийн хүрээнд хугацаанд нь бүрэн байршуулсан, 37 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн 2022 оны санхүүгийн тайлан, аудитын дүгнэлтийн хугацаа болоогүй байгаа тул мэдээлээгүй байна, өмнөх аудитаар өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д “тогтоосон хугацаанд тогтмол, шуурхай мэдээлдэг байх” гэсэн заалттай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллаж хуульд заасан мэдээллийг хугацаанд нь үнэн зөв мэдээлж хэрэгжилтийг нь ханган ажиллах.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

5.2.2 Анхан шатны баримттай холбоотой асуудал:

Илрүүлэлт: Тайлант хугацаанд байгууллагын төсвөөс нийт 3.9 сая төгрөгийн 4 ажил гүйлгээний анхан шатны баримтын иж бүрдэл дутуу байхад санхүүжүүлсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалттай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллаж анхан шатны баримтгүй ажил гүйлгээний анхан шатны баримтын иж бүрдлийг ханган ажиллах, дээрх алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх.

5.2.3 Зардлын бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Тус байгууллага нь 2022 оны 6 сарын 30-ны өдөр Ханхонгор сумын орон сууцны засвар нэртэй 10.7 сая төгрөгийг ХААН банкны 5585244387 тоот дансанд шилжүүлсэн байна. Байгууллагын удирдлагын ХААН банкны 5003507646 тоот дансанд тухайн өдрөө 10.5 сая төгрөг дээрх данснаас шилжүүлсэн байна.

Энэ нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д “Албан тушаалтан өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхолд нийцүүлэн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, мөн эдгээрт бэлтгэхэд өөрийн албан тушаалын байдлаа ашиглан аливаа хэлбэрээр хөндлөнгөөс нөлөөлөхийг хориглоно” гэсэн заалттай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг баримтлан ажиллаж дээрх алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Цалингийн урьдчилгаа данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Тус байгууллагын 2022 онд цалингийн нийт зардал нь 83.5 сая төгрөг байхад байгууллагын удирдлагын авсан цалингийн урьдчилгаа нь 63.2 сая төгрөг байна. Урьдчилгаа дансны үлдэгдэл 10.4 сая төгрөгөөс байгууллагын удирдлагын урьдчилгаа 9.4 сая төгрөг байна.

Энэ нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д “Албан тушаалтан өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхолд нийцүүлэн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, мөн эдгээрт бэлтгэхэд өөрийн албан тушаалын байдлаа ашиглан аливаа хэлбэрээр хөндлөнгөөс нөлөөлөхийг хориглоно” гэсэн заалттай нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Цалингийн урьдчилгааг олгохдоо тухайн албан тушаалтны цалинд багтаан Хөдөлмөрийн тухай хуулийн 104.1-д заасны дагуу сүүлийн хагаст буцаан суутган авах боломжтой хэмжээгээр нь олгож удирдлагад олгосон урьдчилгааг яаралтай барагдуулан ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 10 дугаар сарын 15 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/												
Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Авлагыг дутуу бүртгэсэн	1	1,000.0			1	1,000.0	1	1,000.0				
Дүн	1	1,000.0			1	1,000.0	1	1,000.0				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/												
Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлаг а тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллага д шилжүүлсэ н асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Урамшуулал илүү олгосон	1	869.0	1	869.0								
Өөрийн дансаар мөнгөн хөрөнгө авсан	1	10,492.0			1	10,492.0						
Анхан шатны баримтгүй	1	3,866,0			1	3,866,0						
Урьдчилгаа суутгаагүй	1	10,392.5					1	10,392.5				
Дүн	4	25,619.5	1	869.0	2	14,358.0	1	10,392.5				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/									
Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс						
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг мэдээлээгүй	1				1				
Дүн	1				1				
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил									
Дэд дарга ажиллуулсан	1	1,437.8	1	1,437.8					
Дүн	1	1,437.8	1	1,437.8					
Нийт дүн	2	1,437.8	1	1,437.8	1				